

# Мэдээллийн самбар - 9.

## Ойд ангилал хийх нь менежментийг амжилттай явуулах үндэс



Ойн ангилал буюу мэргэжлийн нэр томъёонд ойн болон ландшафтын типологи нь ой болон ландшафтад менежмент амжилттай явуулахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Байгаль цаг уур, геологи, гидрологи, хөрсний бүтэц болон вегетацийн мэдээлэл багтаасан цогц шалгуурт дүгнэлт хийдэг. Ингэж ангилал хийсний үр дүнд талбайн ургах нөхцөл ижил эсэхийг тогтоон хувааж менежмент явуулах хамгийн тохиромжтой аргыг санал болгодог.



Ангилал хийх нь  
хөрсний бүтцэд  
хэрхэн нөлөөлөх  
вэ?

Хөрс нь урт хугацааны явцад бүрэлдэж бий болдог үйл явц бөгөөд үүнэдээ байгаль цаг уур, газрын хэлбэр, газрын хэвлэй дэх чулуулгийн бүтэц, бичил биетнүүд нөлөөлдөг. Түймэр, хөнөөлт шавж, бэлчээр, мод бэлтгэл зэрэг хүрээлэн буй орчинд үзүүлж буй серог нөлөө нь тухайн амьдрах орчны ургамлын бүтцэд нөлөөлдөг. Чийгтэй, хуурай, ялзмагт эсхүүл үржил шимээр ядуу хөрсөнд өөр өөр төрөл зүйлийн мод, ургамал ургадаг.

Домогт Шарын Гол ойн нэгдлийн эзэмшлийн ой болон ойр орчмын голын хөндийн хөрс барагцаалбал хэдэн арваас хэдэн зуун жилийн настай залуу хөрс юм. Хөндийн доод хэсгээр дунд насны буюу хэдэн мянган жилээр, мөн хэдэн зуун мянган жилээр тоологдох настай хөгшин хөрс ч байна.

Хөрс болон байгалийн сөрөг хүчин зүйл түймрийн нөлөөгөөр тус ойн нэгдлийн эзэмшлийн ой болон ойр орчмын газруудаар ойн нарс (*Pinus sylvestris*), хавтаг навчт хус (*Betula platyphylla*) байгалийн өөрийн аясаар ургасан байна. Тухайн амьдрах орчинд ургаж байгаа өвс ургамал нь хөрсний шим тэжээл, усны хэмжээнээс ихээхэн хамаардаг. **Мөн бэлчээрийн талхалтанд их хэмжээгээр өртсөн.**



Ойд бас сургууль  
шиг ангилал хийдэг  
байх нээ!



Зарим ургамал  
жишигээлбэл  
мөөг зөвхөн  
тодорхой хэсэг  
газар ургаж  
байгааг  
анзаарлаа.

Шим тэжээлээр баялаг, чийглэг хөрстэй эндхийн амьдрах орчинд *Equisetum*, *Carex*, *Epilobium*, *Fragaria*, *Rubus*, *Iris* болон бусад төрлийн ургамал ургадаг. Тус ойн нэгдлийн ойн талбайд Kastanozem, Phaeozem a Kambisol (ангилал WRB 2014) төрлийн хөрс дийлэнх нт байдаг. Эндхийн нутгаар ихэд тархсан Luvic Calcic Kastanozem хөрсний хамгийн дээд үе (горизонт) нэг бүрээр O – органик, A – өнгөн хэсгийн ялзмаг, E – элювийн буюу үржил шим ядмаг, Bt – лювийн (шаварлаг, кальци, карбонатаар баялаг) үечлэн зургаар харууллаа.

Хөрсний судалгаа болон ойн ангилал хийсэн үнэн зөв дүгнэлт дээр тулгуурлан ойн менежментийн төлөвлөгөө гаргадаг. Хамгийн тохиромжтой модны төрөл зүйлийг ойжуулалтын ажилд сонгох, мод бэлтгэлийг зөв зохицтой явуулж ойг нөхөн сэргээх нь ойн менежментийн төлөвлөгөөний нэг хэсэг юм.

